



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 дугаар сарын 07 өдөр Дугаар 68

Хэрлэн сум

LXVIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 68 дугаар хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 09:00 цагт цахимаар 80,9 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн Шуурхай штабын Тандалтын багийн одоогийн нөхцөл байдлын мэдээлэл танилцуулах,

Аймгийн Ерөнхий тархвар судлаач

2.Хот, аймаг, сум хооронд зорчих хөдөлгөөн, нийтийн тээврийн талаар сумдын Онцгой комиссоос ирүүлсэн санал танилцуулах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

3.Тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоог сумдад эхлүүлэх эсэх талаар хэлэлцүүлэх,

Авто тээврийн төв

4.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалаар баталсан "Хот хоорондын хөдөлгөөнийг зохицуулах тухай" түр журмыг хэрэгжүүлэн мөрдөж ажиллах,

1.2.Хөлөнбуйр, Баян-Уул сум, Ялалт, Модон, Баянтүмэн гүүрний шалган нэвтрүүлэх хяналтын цэгийг хэвийн үргэлжлүүлэх,

/ М.Бадамсүрэн

/ Хур Г.Нармандах

1.3.Чойбалсан хотоос гарах сум хооронд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээх,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.4.Нийслэл хот болон аймгийн төвөөс сум руу орох чиглэлд хяналт тавих зорилгоор сумын хяналтын цэгийг хэвийн ажиллуулах,

1.5.Сумдад алслагдсан цэг болон Хэрлэн сум тойрсон хяналтын цэгийг татан буулгах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

1.6.Бага насны буюу 5-12 насны вакцингүй хүүхдүүдийг нэг бүрчлэн түргэвчилсэн шинжилгээ авч зорчуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.7.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх албан хаагч нарыг чадавхжуулах,



Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.8.Хот, аймаг, сум хооронд зорчиж буй иргэд 7 хоногийн тусгаарлалтын дэглэмийг мөрдүүлэх, 6 дахь хоногт тандалтын шинжилгээнд хамрагдах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

1.9.Чойбалсан хотын хот хоорондын нийтийн тээврийг 30-аас илүүгүй хүний дүүргэлттэйгээр Даваа, Лхагва, Баасан гарагт, Баян-Уул, Дашбалбар сумын нийтийн тээврийг 7 хоногт нэг удаа 08:00 цагт зорчуулах,

1.10.Ачаа тээврийн жолооч, тээврийн хэрэгсэлд тавих хяналтыг хэвийн үргэлжлүүлэх,

 / М.Бадамсүрэн
 / Хүр Г.Нармандах

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

1.11.Аймгийн Шуурхай штабын дуудлагын төвийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газрын албан хаагч нараас бусад албан хаагч нар, Өргөдлийн багт үүрэг гүйцэтгэж буй албан хаагч нарыг 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс түр амраах,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.12.Сумдын хяналтын цэг өвдөөд эдгэрсэн тухай, вакцинд хамрагдсан тухай, шинжилгээнд хамрагдсан тухай албан бичгийг хянах

Хоёр.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

2.1.Сумдад тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоог зохион байгуулах хариуцлагын гэрээг Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газартай байгуулах,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.2.Тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоог сумдад зохион байгуулахад халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Халхгол сумын Буйр нууранд томилогдож ажилласан ажлын хэсэг ажилласан зардал 1,226,340 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

3.2.Ачаа тээврийн хяналтыг зохион байгуулахад гарсан зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг-д:

3.3.Ачаа тээврийн хяналтыг зохион байгуулахад хяналт тавьж ажиллахад олон нийтийн цагдаа ажилласан зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

/  / М.Бадамсүрэн
/  / Хур Г.Нармандах

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

3.3.Аймгийн Онцгой комиссын Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангийн бүртгэл тооцоо, тайланг гаргаж аймгийн Онцгой комиссын санхүүгийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын ахлах нягтлан бодогчид сар бүр 40 хувийн урамшуулал олгох тухай аймгийн Засаг даргын захирамж гаргах,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

3.4.Аймгийн Онцгой комисст дайчлагдаж ажилласан аймгийн Засаг даргын Тамгын газрын 00-02ДОА улсын дугаартай тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд шаардагдах 3,000,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

3.5.Эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх чиглэлээр албан даалгаврын төсөл боловсруулах,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

4.1.Бүсийн хурдан морины уралдаан болох шийдвэр гарахтай холбогдуулан ажлын хэсэг байгуулах, ажиллах хүн хүчний тооцоог гаргах,



4.2.Бүсийн хурдан морины уралдаан болох шийдвэр гарахтай холбогдуулан бэлтгэл ажлыг хангах

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

4.3.Бүсийн хурдан морины уралдаан болох шийдвэр гарахтай холбогдуулан сумдаас оролцох уяач, хүүхдүүдийн судалгааг гаргах, шинжилгээнд хамруулах талаар бэлтгэл ажлыг хангуулах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн Ш.Ёл-д:

4.4.Бүсийн хурдан морины уралдаан болох шийдвэр гарахтай холбогдуулан уяачидтай хариуцлагын гэрээг байгуулж ажиллах гэрээний төсөл боловсруулах,


/  / М.Бадамсүрэн
/  / Хур Г.Нармандах

АЗДТГ-ын Цэргийн штабын дарга, Онцгой комиссын гишүүн, Баяр наадмын хурдан морины комиссын дарга, дэд хурандаа О.Ганзориг-д:

4.5.Бүсийн хурдан морины уралдаан болох шийдвэр гарахтай холбогдуулан хурдан морины уралдаан зохион байгуулахад гарах зардлын тооцоог гаргах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

4.6.Коронавирус илрүүлэх шинжилгээний нөөц бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА, ХУРАНДАА  Т.НАРМАНДАХ

